



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 429

Улаанбаатар хот

Г Хамгаалалтын зардал
гаргах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" 177 тоот тогтоолоор баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Бүгд Найрамдах Польш Улсын Krakow хотын Ягеллоны их сургуулийн докторантурын төгсөх ангид суралцаж буй Содном овогтой Отгонгэрэлд докторын зэрэг хамгаалах зардалд шаардагдаж буй 3000 /Гурван мянга/ ам.долларын зардлыг Сургалтын төрийн сангаас санхүүжүүлсүгэй.

2.Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР